

Япон Улсын Цог Жавхлант Эзэн Хаан Эрхэм дээд Хатны хамт Монгол Улсад
хийсэн айлчлалын талаарх сэтгэгдэл

2025 оны 7 сарын 13-ны өдөр /Ням/

Энэ удаа Монгол Улсад төрийн хүндэт зочны хувиар уригдан бид хоёр хамтдаа тус улсад айлчлал хийсэндээ баяртай байна. Ерөнхийлөгч У.Хүрэлсүх болон түүний гэргий албан ёсоор угтах ёслол, төрийн хүндэтгэлийн зоог зэргийг сэтгэл зүрхээ шингээн бэлдэхийн сацуу Үндэсний их баяр наадмын нээлтээс өгсүүлээд сур болон шагайн харваа, хурдан морины уралдааныг хамтдаа үзэж сонирхон гайхалтай сайхан хүлээн авсанд гүн талархал илэрхийлье. Мөн очсон газар бүрт монголчууд халуун дотноор хүлээн авсанд баярлалаа. Монгол Улсын Засгийн газар, Монголын ард түмэн Та бүхний эелдэг найрсаг сэтгэлд чин сэтгэлээсээ талархаж байна.

Айлчлалын үеэр албан ёсоор угтах ёслол, төрийн хүндэтгэлийн зоог, Үндэсний их баяр наадмын нээлт, үндэсний уралдаан тэмцээн болоод Гандантэгчэнлин хийд, Хустайн байгалийн цогцолбор зэрэг газарт зочлон Монголын баялаг түүх, соёл, гайхалтай байгальтай биечлэн танилцлаа. Түүнчлэн 2007 онд айлчлал хийж байсантай харьцуулахад эдийн засгийн хөгжлөө даган Монголын нийгэм бүхэлдээ эрчимжин тэлж буйг мэдэрлээ. Монгол-Японы эмнэлэг, Гачууртын усны эх үүсвэр зэрэгтэй танилцах үеэр Япон Улсын олон төрлийн тусламж дэмжлэг, хамтын ажиллагаа энэхүү хөгжилд хувь нэмрээ оруулж байгааг бодитоор харсандаа баяртай байсан.

Түүнчлэн энэ удаагийн айлчлалаар дамжин Япон, Монголын ард иргэдийн дунд олон жилийн турш хуримтлагдан хөгжиж ирсэн найрамдалт, найрсаг харилцааны замналын талаар гүнзгий ойлголттой боллоо. Япон, Монголын харилцаатай олон хэлбэрээр холбогдож ирсэн үе үеийнхэний төлөөлөлтэй нүүр тулан уулзаж байхдаа хоёр орны найрсаг, найрамдалт харилцаа нь хүмүүсийн хэлхээ холбооны үндсэн дээр гүнзгийрч ирснийг мөн монголчуудын Япон орны талаарх халуун дотно хандлагыг мэдэрсэндээ баяртай байлаа. Нийслэлийн ерөнхий боловсролын 149 дүгээр сургууль, Монгол Коосэн технологийн коллеж зэрэг газарт Монголын хүүхэд залуучуудтай уулзаж ярилцсан билээ. Залуу хойч үеийнхэн цаашид ч харилцан бие биенийхээ улсын талаар гүнзгий сонирхон судалж, хоёр орны харилцан ойлголцол, найрамдалт харилцаанд томоохон үүрэг гүйцэтгэнэ хэмээн найдаж байна.

Япон иргэдийн дурсгалын цогцолборт цэцэг өргөхдөө, хүний эрхээр эх орноосоо хол, хүний нутагт нас барсан хүмүүст хүндэтгэлээ илэрхийлсэн бөгөөд миний

сэтгэлд гүн хоногшин үлдлээ. Мөн Монголын Улаан загалмайн нийгэмлэгийн хамт олон тус дурсгалын цогцолборыг хайрлан хамгаалж, арчилж байгаад талархаж байна. Урд өмнө болсон дайнд амь үрэгдсэн хүмүүсийг үл мартан, өнгөрсөн түүхийг илүү гүнзгий ойлгож, энх тайвныг эрхэмлэн хайрлах сэтгэлийг төлөвшүүлэх нь чухал хэмээх бодол дахин төрлөө.

Бид хоёр хамтдаа анх удаа Монгол оронд айлчлал хийсэн маань мартагдашгүй дурсамж болон үлдлээ. Энэхүү айлчлалын бэлтгэл ажлыг хангахад хүчин чармайлт гаргасан Япон, Монгол хоёр талын холбогдох олон хүмүүст гүнээ талархаж байна. Энэ удаагийн айлчлалын үр дүнд хоёр орны ард түмний харилцан ойлголцол улам гүнзгийрч, Япон, Монголын найрамдал, нөхөрлөл, хамтын ажиллагаа цаашид өргөжин хөгжихийг чин сэтгэлээсээ хүсэж байна.